



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Пүрэвжавын САЙНЗОРИГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
<http://www.parliament.mn>

2026-06-10 № УИХ-03/6745  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



П.САЙНЗОРИГ  
Ж.АЛДАРЖАВХЛАН  
О.АЛТАНГЭРЭЛ  
Н.АЛТАНХУЯГ  
Н.АЛТАНШАГАЙ  
Д.АМАРБАЯСГАЛАН  
С.АМАРСАЙХАН  
О.АМГАЛАНБААТАР  
Ч.АНАР  
А.АРИУНЗАЯА


000000168




Т.АУБАКИР  
Х.БААСАНЖАРГАЛ  
Ц.БААТАРХҮҮ  
М.БАДАМСҮРЭН  
Э.БАТ-АМГАЛАН  
Б.БАТБААТАР



Д.БАТБАЯР  
Р.БАТБОЛД  
Ж.БАТЖАРГАЛ  
Д.БАТЛУТ  
О.БАТНАЙРАМДАЛ



Ж.БАТСУУРЬ  
Н.БАТСҮМБЭРЭЛ  
Х.БАТТУЛГА  
Б.БАТЦЭЦЭГ  
П.БАТЧИМЭГ  
Э.БАТШУГАР



Б.БАТ-ЭРДЭНЭ



Ж.БАТ-ЭРДЭНЭ  
Б.БАЯРБААТАР  
Ж.БАЯРМАА  
Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРМАА



Э.БОЛОРМАА

000000168

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

 А.ГАНБААТАР


Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ



Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ



М.ГАНХҮЛЭГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН



Х.ЖАНГАБЫЛ

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ

**000000168**



Ж.ЗОЛЖАРГАЛ

С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

Т.МӨНХСАЙХАН

Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР



0000001F8

Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТУЛГА

Б.ТҮВШИН

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

ДАВ.ЦОГТБААТАР

000000168

*Handwritten signature*

*Handwritten signature*

*Handwritten signature*

*Handwritten signature*

ДАМ.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТУЯА

Д.ЭНХТҮВШИН

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН





УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Пүрэвжавын САЙНЗОРИГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
<http://www.parliament.mn>

2026.05.22 № УИХ-ОБ/5872  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт ~~2~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



П.САЙНЗОРИГ

000000161



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
П.САЙНЗОРИГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.18 № ХТ/1690  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265004453

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“10.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригоос санаачлан боловсруулсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригоос санаачлан боловсруулсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд хуулийн төслийг дэмжих боломжгүй гэж үзэж, дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төсөлд “контент” гэх нэр томъёог хэрэглэсэн боловч уг нэр томъёо нь Төрийн албаны тухай хуульд хэрэглэгддэггүй тул агуулга, хүрээг нь тодорхой болгох шаардлагатай. Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсэгт “Нэр томъёо нь тодорхой утга агуулгаар зөвхөн нэг бүлэг, зүйл, хэсэг, заалтын хүрээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолт, тайлбарыг холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтын дотор байрлуулж болно” гэж заасан.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад “контент” гэж харилцаа холбооны сүлжээгээр дамжиж байгаа үг, дуу, тэмдэг, дохио, текст, зураг, график, хөдөлгөөнт дүрс бүхий бүх төрлийн мэдээ, мэдээллийг электрон хэлбэрт хувиргасныг ойлгохоор тодорхойлсон байна.

Иймд холбогдох хуулийн заалтыг эшлэх, эсхүл нэр томъёоны тайлбарыг тусгах шаардлагатай;

2.Хуулийн төсөлд “өөрийн нийгмийн сүлжээнд оруулсан контент, мэдээ, мэдээллээ ... түгээх” гэж тусгасан боловч “дамжуулах”, “хуваалцах”, “дахин нийтлэх” зэрэг үйлдлүүдийг хамруулах эсэх, түүнчлэн, гуравдагч этгээдээр дамжуулан түгээсэн мэдээлэлд хамаарах эсэхийг ялган зааглаагүй байгаа нь хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэл үүсгэж болзошгүй байна.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт иргэний “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх” эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд хуулийн төслийн зохицуулалтыг хэт ерөнхий байдлаар тусгасан нь Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэний эдлэх үндсэн эрх, эрх чөлөөтэй зөрчилдөхөөр байна;

3.Хуулийн төсөлд тусгасан “бусад тохиолдолд” гэсэн томъёолол нь хэт ерөнхий, тодорхой бус байгаа нь хууль хоёрдмол утгагүй, тодорхой, ойлгомжтой байх зарчимд нийцэхгүй байна;

4.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд сонгуулийн сурталчилгаа, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах зэрэг өөр өөр зорилго, эрх зүйн


шинжтэй харилцааг нэг заалтад нэгтгэн тусгасан нь хуулийг хэрэглэх явцад зөрүүтэй ойлголт үүсгэх эрсдэлтэй байна;

5.Хуулийн төсөлд төрийн албан хаагчийн нийгмийн сүлжээ ашиглахыг хязгаарлахаар тусгасан нь төрийн байгууллагын олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй зөрчилдөх эрсдэлтэй байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар төрийн байгууллага мэдээллийг ил тод, шуурхай түгээх, олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах үүрэгтэй.

Иймд төрийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийг хязгаарлахгүйгээр зохицуулалтыг уялдуулах, төрийн албан хаагчийн төвийг сахих болон мэдээлэл түгээх чиг үүргийг ялган тодорхойлж, албан ёсны мэдээлэл түгээх үйл ажиллагааг хэт өргөн хүрээгээр хориглохгүй байх нь зүйтэй;

6.Төрийн байгууллагын албан ёсны цахим хуудас ашиглахтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгож, албан ёсны мэдээлэл түгээх болон улс төрийн агуулгатай үйл ажиллагааг ялган зохицуулах;

7.Зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуультай уялдуулан тодорхой болгох шаардлагатай.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН**



**П.САЙНЗОРИГ**

2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.13 дахь заалтад зааснаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээхийг төрийн албан хаагчдын хориглодог боловч тус зүйлийн тайлбарт зааснаар энэ улс төрийн албан хаагчдад хамаарахгүй байхаар хуульчилсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд нэгдсэн болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлж хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль тогтоомжийн төсөл, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй.” гэж заасан байдаг.

Дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд улс төрийн албан хаагч нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албаны болон албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээх түгээмэл бөгөөд энэхүү үйл ажиллагааг төлбөртэйгээр идэвхжүүлэн түгээх, зарим тохиолдолд төрийн байгууллагын нийгмийн сүлжээний цахим хуудасыг ашиглах явдал нэлээдгүй гарч байна.

Энэ нь төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгож, олон нийтэд тайлагнах гэхээсээ илүүтэйгээр хувь хүний сурталчилгаа, зарим тохиолдолд улс төрийн зорилгоор хуурамч мэдээллийг түгээж олон нийтийг төөрөгдүүлж иргэдийн мэдэх эрхийг зөрчих, улс төрийн шударга бус өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна.

Монгол Улс дахь төрийн 4.276 байгууллагад 226.895 төрийн албан хаагч ажиллаж байна. Үүнээс улс төрийн албан хаагч 3823, төрийн захиргааны албан хаагч 21350, төрийн тусгай 49081, төрийн үйлчилгээний 152641 албан хаагч байна.

Meta Ad Library Report-д дурдсанаар 2020 оны 8 дугаар сараас нийгэм, улс төр, сонгуультай холбоотой 56906<sup>5</sup> төлбөртэй сурталчилгаа фэйсбүүк платформ оруулж, \$2,238,838 буюу ₮8 орчим тэрбумыг төлсөн байна.

<sup>5</sup> 2026 оны 3 дугаар сарын 22-ны өдөр сүүлд нэвтрэв.

Түүнчлэн арилжааны банкууд иргэн, аж ахуйн нэгжүүдийн гадаад төлбөр тооцоог олон улсын картын сүлжээ болон свифт төлбөрийн системээр дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд Монголбанк арилжааны банкуудаас зөвхөн свифт системээр дамжин хийгдэж буй тавин мянган ам.доллараас дээш дүнтэй гадаад гүйлгээний мэдээллийг хүлээн авдаг байна. Мета Платформ компанийн түнш байгууллагаас тус компани руу 2023 оноос хойш 12.1 сая ам.долларын үйлчилгээний төлбөрийг шилжүүлсэн талаарх мэдээлэл бүртгэгдсэн байна.<sup>6</sup>

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл 2 зүйлтэй байх бөгөөд Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшиж хуулиар зөвшөөрөгдсөн сурталчилгааны хугацаанд болон гэмт хэрэг, зөрчил, гамшгаас хамгаалахаас бусад тохиолдолд өөрийн нийгмийн сүлжээнд оруулсан контент, мэдээ, мэдээллээ төлбөртэйгээр идэвхжүүлэн түгээхгүй байх, энэ зорилгоор төрийн байгууллагын нийгмийн сүлжээний цахим хуудасыг ашиглахгүй байхаар тусгана.

**Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдснаар төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, олон нийтэд төрийн байгууллагын үйл ажиллагааг тайлагнах ажилагааг улс төрийн зорилгоор ашиглахгүй байхад түлхэц болно. Түүнчлэн улс төрийн зорилгоор хуурамч мэдээлэл түгээж олон нийтийг төөрөгдүүлж иргэдийн мэдэх эрхийг зөрчих, иргэдийн шийдвэр гаргах байдалд зохисгүй байдлаар нөлөөлөх, улс төрийн шударга бус өрсөлдөөнийг хязгаарлана.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулна.

---o0o---

---

<sup>6</sup>Монголбанкны Ерөнхийлөгчийн 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А-1/222 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригт ирүүлсэн мэдээлэл.

## ТАНИЛЦУУЛГА/ товч/

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, олон нийтэд төрийн байгууллагын үйл ажиллагааг тайлагнах ажилагааг улс төрийн зорилгоор ашиглахгүй байх, ялангуяа улс төрийн зорилгоор хуурамч мэдээлэл түгээх олон нийтийг төөрөгдүүлж иргэдийн мэдэх эрхийг зөрчих, иргэдийн шийдвэр гаргах байдалд зохисгүй байдлаар нөлөөлөх, улс төрийн шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшиж хуулиар зөвшөөрөгдсөн сурталчилгааны хугацаанд болон гэмт хэрэг, зөрчил, гамшигаас хамгаалахаас бусад тохиолдолд өөрийн нийгмийн сүлжээнд оруулсан контент, мэдээ, мэдээллээ төлбөртэйгээр идэвхжүүлэн түгээхгүй байх, энэ зорилгоор төрийн байгууллагын нийгмийн сүлжээний цахим хуудасыг ашиглахгүй байх зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулахаар хуулийн төсөл боловсрууллаа. Хуульд заалт нэмж байгаатай холбогдуулан дараагийн заалтын дугаарыг өөрчлөхөөр мөн тусгалаа.

Мөн хуулийн төсөлд “контент” гэж олон нийтийн сүлжээгээр дамжиж байгаа үг, дуу, тэмдэг, дохио, текст, зураг, график, хөдөлгөөнт дүрс бүхий бүх төрлийн мэдээ, мэдээллийг электрон хэлбэрт хувиргасныг, “нийгмийн сүлжээний хэрэгсэл” гэж цахим орчинд хэрэглэгч контент үүсгэх, түүнийг бусад хэрэглэгч, нийтэд түгээх, ил болгох болон устгах боломжтой, бусадтай харилцах, мэдээлэл харилцан солилцох зориулалт бүхий, хэрэглэгчийн үүсгэсэн контентод суурилсан сүлжээг, “түгээх” гэж хэрэглэгч контент, мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээний тодорхойгүй хүрээний хэрэглэгчид болон нийтэд нээлттэй хүргэхийг;” гэж зарим нэр томъёоны тайлбарыг тусгалаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хурлын тамгын газрын <https://d.parliament.mn/> цахим сайтад байршуулан олон нийтээс санал авч байна.

## ТАНИЛЦУУЛГА/ дэлгэрэнгүй/

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.13 дахь заалтад зааснаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээхийг төрийн албан хаагчдын хориглодог боловч тус зүйлийн тайлбарт зааснаар энэ улс төрийн албан хаагчдад хамаарахгүй байхаар хуульчилсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд нэгдсэн болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлж хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль тогтоомжийн төсөл, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй.” гэж заасан байдаг.

Дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд улс төрийн албан хаагч нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албаны болон албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээх түгээмэл бөгөөд энэхүү үйл ажиллагааг төлбөртэйгээр идэвхжүүлэн түгээх, зарим тохиолдолд төрийн байгууллагын нийгмийн сүлжээний цахим хуудасыг ашиглах явдал нэлээдгүй гарч байна.

Энэ төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгож, олон нийтэд тайлагнах гэхээсээ илүүтэйгээр хувь хүний сурталчилгаа, зарим тохиолдолд улс төрийн зорилгоор хуурамч мэдээллийг түгээж олон нийтийг төөрөгдүүлж иргэдийн мэдэх эрхийг зөрчих, улс төрийн шударга бус өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна.

Meta Ad Library Report-д дурдсанаар 2020 оны 8 дугаар сараас нийгэм, улс төр, сонгуультай холбоотой 56906<sup>7</sup> төлбөртэй сурталчилгаа фэйсбүүк платформ оруулж, \$2,238,838 буюу ₮8 тэрбумыг төлсөн байна.

Иймд Төрийн албаны тухай хуульд Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшиж хуулиар зөвшөөрөгдсөн сурталчилгааны хугацаанд болон гэмт хэрэг, зөрчил, гамшигаас хамгаалахаас бусад тохиолдолд өөрийн нийгмийн сүлжээнд оруулсан контент, мэдээ, мэдээллээ төлбөртэйгээр идэвхжүүлэн түгээхгүй байх, энэ зорилгоор төрийн байгууллагын нийгмийн сүлжээний цахим хуудасыг ашиглахгүй байхаар тусгалаа.

Мөн хуулийн төсөлд “контент” гэж олон нийтийн сүлжээгээр дамжиж байгаа үг, дуу, тэмдэг, дохио, текст, зураг, график, хөдөлгөөнт дүрс бүхий бүх төрлийн мэдээ, мэдээллийг электрон хэлбэрт хувиргасныг, “нийгмийн сүлжээний хэрэгсэл” гэж цахим

<sup>7</sup> 2026 оны 3 дугаар сарын 22-ны өдөр сүүлд нэвтрэв.

орчинд хэрэглэгч контент үүсгэх, түүнийг бусад хэрэглэгч, нийтэд түгээх, ил болгох болон устгах боломжтой, бусадтай харилцах, мэдээлэл харилцан солилцох зориулалт бүхий, хэрэглэгчийн үүсгэсэн контентод суурилсан сүлжээг, “түгээх” гэж хэрэглэгч контент, мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээний тодорхойгүй хүрээний хэрэглэгчид болон нийтэд нээлттэй хүргэхийг;” гэж зарим нэр томъёоны тайлбарыг тусгалаа.

Хуулийн төсөл батлагдснаар төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, олон нийтэд төрийн байгууллагын үйл ажиллагааг тайлагнах ажиллагааг улс төрийн зорилгоор ашиглахгүй байхад түлхэц болно. Түүнчлэн улс төрийн зорилгоор хуурамч мэдээлэл түгээж олон нийтийг төөрөгдүүлж иргэдийн мэдэх эрхийг зөрчих, иргэдийн шийдвэр гаргах байдалд зохисгүй байдлаар нөлөөлөх, улс төрийн шударга бус өрсөлдөөнийг хязгаарлана.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хурлын тамгын газрын <https://d.parliament.mn/> цахим сайтад байршуулан олон нийтээс санал авч байна.

----o0o----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 39.1.18 дахь заалт нэмсүгэй:

“39.1.18.Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшиж хуулиар зөвшөөрөгдсөн сурталчилгааны хугацаанд болон гэмт хэрэг, зөрчил, гамшгаас хамгаалахаас бусад тохиолдолд өөрийн нийгмийн сүлжээний хэрэгсэлд оруулсан контент, мэдээ, мэдээллээ төлбөртэйгөөр идэвхжүүлэн түгээх, энэ зорилгоор төрийн байгууллагын нийгмийн сүлжээний цахим хуудсыг ашиглах;

Тайлбар: -Энэ хуульд заасан “контент” гэж олон нийтийн сүлжээгээр дамжиж байгаа үг, дуу, тэмдэг, дохио, текст, зураг, график, хөдөлгөөнт дүрс бүхий бүх төрлийн мэдээ, мэдээллийг электрон хэлбэрт хувиргасныг;

-“нийгмийн сүлжээний хэрэгсэл” гэж цахим орчинд хэрэглэгч контент үүсгэх, түүнийг бусад хэрэглэгч, нийтэд түгээх, ил болгох болон устгах боломжтой, бусадтай харилцах, мэдээлэл харилцан солилцох зориулалт бүхий, хэрэглэгчийн үүсгэсэн контентод суурилсан сүлжээг;

-“түгээх” гэж хэрэглэгч контент, мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээний тодорхойгүй хүрээний хэрэглэгчид болон нийтэд нээлттэй хүргэхийг;”

**2 дугаар зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 39.1.18 дахь заалтын дугаарыг “39.1.19” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг